

АЖЛЫН ДААЛГАВАР

Төслийн нэр	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нэгдсэн төсөл
Байршил	Монгол Улс, Улаанбаатар
Ажлын даалгаврын нэр	Тэтгэврийн шинэчлэлийн зөвлөх (дата аналит)
Үйлчилгээний нэр	Нийгмийн даатгалын мэдээллийн сангийн дүн шинжилгээ, интерактив хяналтын самбар хөгжүүлэх
Гэрээний төрөл	Зөвлөх үйлчилгээ
Хэлний мэдлэг:	Монгол, Англи хэл
Гэрээний хугацаа:	2026.06.15-11.16 (5 сар)

ҮНДЭСЛЭЛ

Нийгмийн даатгалд 2025 оны байдлаар шимтгэл төлөгч ажил олгогч 63.7 мянга, 1,350.0 мянган даатгуулагч хамрагдсан нь Монгол Улсын нийт ажиллах хүчний 80 орчим хувийг эзэлж байна. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын статистик мэдээллээр санд 6.5 их наяд төгрөгийн орлого төвлөрсөн бол нийгмийн даатгалын сангаас давхардсан тоогоор 725.0 мянган хүний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт 5.9 их наяд төгрөг зарцуулсан байна. Тухайлбал, тэтгэврийн даатгалын сангийн орлого 4.2 их наяд төгрөг, зарлага 5.3 их наяд төгрөг байна. Тэтгэврийн зардалд улсын төсвөөс 1.5 их наяд төгрөгийг санхүүжилт олгосон бөгөөд үүнээс цэргийн алба хаагчийн тэтгэврийн зардал 404.0 тэрбум төгрөг, 1995 оноос өмнө тогтоолгосон тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт 338.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Мөн нийгмийн даатгалын сангийн 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр зарлага 6.6 их наяд төгрөг байгаа нь улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын 20 хувь, ДНБ-ний 6.5 хувийг эзэлж байна.

Нийгмийн даатгалын мэдээллийн сан нь даатгуулагч, тэтгэвэр авагчийн тоо, хөдөлгөөн, шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмж олголттой холбоотой их хэмжээний өгөгдлийг агуулдаг боловч уг өгөгдлийг системтэйгээр нэгтгэн боловсруулж, бодлогын шийдвэр гаргалтад ашиглах чадавх одоогоор хязгаарлагдмал байна. Тэтгэврийн шинэчлэлийн явцад шинэчлэлийн хувилбар бүрийн нөлөөллийг өгөгдөлд тулгуурлан тооцоолох, даатгуулагчдын хамрагдалтын ялгаатай байдлыг шинжлэх, сангуудын санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэх зэрэг ажилд найдвартай, чанартай мэдээлэл шаардлагатай байна. Мөн шийдвэр гаргагчид болон оролцогч талуудад мэдээллийг ойлгомжтой, хялбар хэлбэрээр хүргэх интерактив хяналтын самбар, стандартчилсан тайлагналтын тогтолцоо бий болгох хэрэгцээ байна.

Иймээс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь нийгмийн даатгалын мэдээллийн сангийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, өгөгдөлд суурилсан бодлогын нөлөөллийн үнэлгээ хийх, интерактив хяналтын самбар хөгжүүлэх болон холбогдох албан хаагчдын чадавхыг сайжруулах, хамтран ажиллах чиглэлээр мэргэжлийн дата аналит зөвлөх ажиллуулахаар төлөвлөж байна. Энэхүү ажлын даалгавар нь тэтгэврийн шинэчлэлийн зөвлөх (дата аналит)-ийн гүйцэтгэх ажлын цар хүрээ болон нийлүүлэх бүтээгдэхүүнийг тодорхойлно. Зөвлөх нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ) болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын (НДЕГ) холбогдох албан тушаалтнуудтай нягт хамтран ажиллаж, энэхүү ажлын даалгаварт тусгагдсан бүх үр дүн, бүтээгдэхүүнийг хугацаанд нь, мэргэжлийн түвшинд гүйцэтгэн хүлээлгэн өгөх үүрэгтэй байна.

ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Ажлын зорилго:

- Нийгмийн даатгалын шинэчлэлийн хүрээнд тэтгэврийн тогтолцоо, параметрийн шинэчлэлүүдийн орлого, зарлагын нөлөөллийн үрт хугацааны тооцоо судалгааг хийх ;
- Холбогдох албан хаагчдын өгөгдөлд дүн шинжилгээ хийх мэдлэг, техникийн үр чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

Ажлын хүрээ:

- Нийгмийн даатгалын сангийн их өгөгдлийг нэгтгэх, цэгцлэх, чанаржуулах, боловсруулалт хийх замаар өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ хийж, даатгуулагч, тэтгэвэр авагчийн зан төлөв, хөдөлгөөний урсгалыг тодорхойлох, сангуудын орлого, зарлагын төлөв байдлыг үнэлэх;
- Даатгуулагчдын тэтгэврийн шинэчлэлийн хувилбаруудын үзүүлэх үр нөлөөг үнэлэх техникийн хүрээ, аргачлал болон үнэлгээний загварыг боловсруулах. Түүнчлэн тэтгэвэрт гарсан он, нас, хүйсээр ангилсан тэтгэврийн хувь хэмжээ, тэтгэврийн хуваарилалтын үзүүлэлт зэрэг нийгмийн үр нөлөөг үнэлж, тэтгэврийн шинэчлэлийн хувилбартай холбоотой Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын чиг хандлагыг үнэлэх;
- ГБХНХЯ болон НДЕГ-ын Холбогдох албан хаагчдын өгөгдөлд дүн шинжилгээ хийх мэдлэг, техникийн үр чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- ГБХНХЯ болон Дэлхийн банкны техникийн багтай нягт хамтран ажиллана.

Гүйцэтгэх ажлууд:

1) Нийгмийн даатгалын мэдээллийн санг дүн шинжилгээ хийхэд бэлтгэх:

- Нийгмийн даатгалын мэдээллийн сангийн их өгөгдлийг цэгцлэх, нэгтгэх, боловсруулах;
- Давхардал, алдаа, орхигдсон утгыг тодорхойлж, засварлах аргачлал боловсруулах;
- Мэдээллийн урсгалын диаграм, метадата баримтжуулалт үүсгэх.

2) Өгөгдлийн дүн шинжилгээ, шинэчлэлтэй холбоотой тооцоололхийх:

Тэтгэврийн шинэчлэлийн хувилбарын хүрээнд тэтгэврийн түвшний чиг хандлага, насны бүлэг, тэтгэвэрт гарсан он, хүйсээрх тэтгэврийн хуваарилалтад дүн шинжилгээ хийх. Үүнд:

- Тэтгэврийн доод хэмжээ болон суурь тэтгэврийн бодлогын зохистой байдал, тэдгээрийн санхүүгийн үр нөлөөг үнэлэх;
- (NDC) тогтолцоог хадгалах, өөрчлөх, болон цуцлахтай холбоотой бодлогын хувилбаруудын тооцооллыг хийх;
- Тэтгэврийн нөөц сангийн хуримтлалд суурилсан (DC) тогтолцооны шинэчлэлтэй холбоотой тооцооллыг хийх;
- Одоогийн тогтоосон тэтгэврийн (DB) тогтолцооны хүрээнд шинэчлэлийн хувилбарууд болон параметрийн өөрчлөлтүүдийн тооцооллыг хийх;
- Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын төлөв байдалд дүн шинжилгээ хийж, дүнд хугацааны төсөөллийг боловсруулах;
- Шинэчлэлийн хувилбарын хүрээнд бодлогын өөрчлөлт, шинэчлэлийн үр нөлөөг үнэлэх.

3) Мэдээллийн визуалчлал ба тайлагнах:

- Шинэчлэлийн загварчлалын үр дүнг танилцуулахад зориулсан интерактив хяналтын самбар болон өгөгдлийн визуалчлалыг боловсруулах.

4) Чадавх бэхжүүлэх ба техникийн дэмжлэг:

- ГБХНХЯ-ны холбогдох албан хаагчдад мэдээллийн сангийн шинжилгээний чадавх дамжуулах семинар зохион байгуулах;
- Мэдээлэл ашиглалтын гарын авлага, аргачлал боловсруулах.

Нийлүүлэх бүтээгдэхүүн:

Зөвлөх нь дараах бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.

Сар бүрийн явцын тайлан

Зөвлөх нь тайлант хугацаанд хийсэн ажлын явц, болон хүрсэн үр дүнг тусгасан явцын тайланг сар бүр ирүүлнэ.

Сарын тайланд дараах мэдээллийг тусгана.

- Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны танилцуулга;
- Өгөгдлийг нэгтгэх, цэгцлэх, боловсруулах болон чанарын баталгаажуулалтын ажлын явц;
- Тэтгэврийн шинэчлэлтэй холбоотой тооцоо, загварчлал болон дүн шинжилгээний ажлын явц;
- ГБХНХЯ, Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ) болон Дэлхийн банкны техникийн багт дэмжлэг үзүүлж ажилласан ажлын явц;
- Холбогдох албан хаагчдын өгөгдөлд дүн шинжилгээ хийх мэдлэг, техникийн үр чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт хийсэн ажлын тайлан;
- Тулгарсан гол хүндрэл, бэрхшээл болон түүнийг шийдвэрлэх санал;

- Дараа сарын тайлант хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаа.

Гэрээний хугацаа: 2026.05.15 - 2026.11.16 (5сар) Гэрээний хугацааг сунгах боломжгүй.

Гэрээний үнэ: 54,000,000 төгрөг.

Мониторинг, явцын хяналт, тайлагналтад тавигдах шаардлагууд:

Зөвлөх нь дээр дурдсан ажлыг ГБХНХЯ болон НТХН-ийн удирдамж, хяналтын дор гүйцэтгэнэ. Зөвлөхийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

- 1) Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;
- 2) Төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал;
- 3) Гүйцэтгэсэн ажлын чанар.

Тайлагналт:

Зөвлөх нь ГБХНХЯ болон НТХН-д ажлаа тайлагнаж ажиллана. Зөвлөх нь гэрээний төлбөрийн хуваарьт заасан төлбөр авахын өмнө ГБХНХЯ болон НТХН-д Бүтээгдэхүүн хүлээж авах маягтыг бөглөж ирүүлнэ.

Төлбөрийн хуваарь:

Зөвлөхийн нийлүүлсэн бүтээгдэхүүнийг ГБХНХЯ/НТХН хүлээн авсны дараа төлбөрийг олгоно.

Зөвлөхөд гэрээний хугацаанд сар бүрийн явцын тайланг ирүүлж, хариуцсан үүрэг, даалгаврыг хангалттай гүйцэтгэсэн болохыг ГБХНХЯ баталгаажуулсны үндсэн дээр сар бүрийн төлбөрийг олгоно.

Сар бүрийн явцын тайланд тайлант хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, боловсруулсан үр дүн, үзүүлсэн техникийн дэмжлэг, тулгарсан хүндрэл, бэрхшээл, мөн дараагийн тайлант хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлыг нэгтгэн тусгана.

Сар бүрийн төлбөр нь гэрээний нийт үнийн дүнгийн 20 хувьтай тэнцүү байна.

Эцсийн төлбөрийг сүүлийн сарын явцын тайлан, мөн гэрээнд заасан бүх үүргийг бүрэн гүйцэтгэсэн нөхцөлд олгоно.

ШААРДЛАГАТАЙ УР ЧАДВАР, АЖЛЫН ТУРШЛАГА

Боловсрол:

- Статистик, компьютерын шинжлэх ухаан, өгөгдлийн шинжлэх ухаан, эдийн засаг, эсвэл холбогдох чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх.

Туршлага:

- Их өгөгдлийн шинжилгээ, мэдээллийн сан удирдлага болон дүн шинжилгээний чиглэлээр 5-аас доошгүй жилийн туршлагатай байх;
- Нийгмийн даатгал, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлийн мэдээллийн сантай ажилласан туршлагатай бол давуу тал болно;

Ур чадвар:

- Excel, Access, Stata болон түүнтэй адилтгах программ хангамж, хэрэгслийг мэргэжлийн түвшинд ашиглах мэдлэг, ур чадвартай байх; SQL, Power BI эсвэл Tableau ашиглаж байсан туршлагатай бол давуу тал болно;
- Мэдээллийг визуалчлах, тайлан бэлтгэх чадвартай;
- Монгол, Англи хэлний мэдлэгтэй байх.